



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/187

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 29.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 тоот тогтоолоор баталсан "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвижих багийн нутаг дэвсгэрт хуучнаар Сайнцагааны орон сууцны доорх 897 м.кв газрыг хавсралтанд заасан 2 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшигчдийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан)-д зөвшөөрсүгэй.
3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ